



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 01 сарын 30 өдөр

Дугаар А/25

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2024 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн А/36 дугаар “Өвөлжилт хүндэрсэн малчдад өвс, тэжээл үнэгүй олгох тухай” захирамж, сумын Онцгой комиссын 2024 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрсэнтэй холбогдуулан Аймгийн Аюулгүйн нөөцөөс суманд хуваарилагдсан, малчдад үнэгүй олгох өвс, тэжээлийг зөөвөрлөж авч ирэх шатахууны зардалд 550,000 (таван зуун тавин мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Шатахууны зардалд зарцуулагдах 550,000 (таван зуун тавин мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу анхан шатны баримт бичгийн бүрдлийг ханган зарцуулж, үнэн зөв тайлагнахыг нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4.Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА